

АСУУЛТ 1: Иргэн : Шинээр төрсөн хүүхдийг бүртгүүлэхэд ямар бичиг баримт бүрдүүлж ирэх вэ?

ХАРИУЛТ 1: Дараах бичиг баримтыг бүрдүүлж ирэх: Үүнд: - Эмнэлгийн байгууллагаас регистрийн дугаар олгосон байх

-Эмнэлгээс СТ-4 маягт авч ирэх

-Гэрлэлтийн баталгаатай бол эцэг, эхийн иргэний үнэмлэх, гэрлэлтийн баталгаатай байх

-Гэрлэлтээ батлуулаагүй эцэг, эх хүүхдээ эцгээр нь овоглох бол эцэг, эхийн тус тусдаа гаргасан өргөдөл иргэний үнэмлэхний хуулбар

-Гэрлэлтийн баталгаагүй эхээрээ овоглох хүсэлтэй бол эхийн өргөдөл иргэний үнэмлэхний хуулбар

-Төрсний бүртгэлийг 30 хоногийн дотор бүртгүүлэх

Жич: Хугацаа хэтэрсэн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 15.24.1 дэх заалтын дагуу хорин нэгжтэй тэнцэх шийтгэл оногдуулна. Харьяалал харгалзахгүй бүртгэл

АСУУЛТ 2: Иргэн: Бид 2 гэрлэлтээ батлуулах гэсэн юм. Ямар бичиг баримт бүрдүүлж ирэх вэ.

ХАРИУЛТ 2: Тус тусдаа гаргасан өргөдөл

-Гэрлэгсдийг хүсэгчдийн иргэний үнэмлэх

-2 гэрчийг байлцуулна. /Гэрчээр 18 нас хүрсэн иргэн байна./

-Гэрлэгчдийн эрүүл мэндийн шинжилгээний бичиг /ДОХ,Сүрьеэ,Сэтгэц/

-Гэрчилгээний үнэ /2500/ /ХААН банк- 5046293699 дансанд тушаах/

Жич: Харьяалал харгалзахгүй бүртгэл

Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл

АСУУЛТ 3: Иргэн: Шүүхээр гэрлэлтээ цуцлуулсан юм. Ямар бичиг баримт байх шаардлагатай вэ.

ХАРИУЛТ 3: Шүүхийн журмаар бол гэрлэлтийг цуцалсан шүүхийн шийдвэр

-Иргэний үнэмлэхний хуулбар /тухайн гэрлэгсдийн хэн нэгэн бүртгүүлэхээр ирэхэд иргэний үнэмлэх, гэрлэлтийн гэрчилгээ ба гэрлэлтийн лавлагаа / авч ирэх.

Жич: Шүүхийн шийдвэрийн хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 3 хоногийн дотор бүртгүүлэх. Хугацаа хэтэрсэн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 15.24.1 дэх заалтын дагуу хорин нэгжтэй тэнцэх шийтгэл оногдуулна.

-Мөн захиргааны журмаар гэрлэлтээ цуцалж байгаа бол тус тусдаа гаргасан өргөдөл

- Иргэний үнэмлэх

- Гэрлэлтийн гэрчилгээ

- Захиргааны журмаар гэрлэлт цуцлуулж байгаа иргэн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирэх боломжгүй бол өргөдлийг нотариатаар гэрчлүүлсэн байна.

Жич : Харьяалал харгалзахгүй бүртгэл

Иргэний үнэмлэх шинээр авах:

АСУУЛТ 4: Манай хүүхэд одоо 16 нас хүрч байна. Бүрдүүлэх бичиг баримт юу байх вэ.

ХАРИУЛТ4 : 16 нас хүрч иргэний үнэмлэх шинээр авахад бүрдүүлэх материалд

-Төрсний гэрчилгээ эх хувь, хуулбар

-Эцэг, эхийн иргэний үнэмлэхний эх хувь, хуулбар

-Өөрийн биеэр ирэх

Үйлчилгээний хураамж: Иргэний үнэмлэхний үнэ 15000 ХААНБанк 5046310388, тэмдэгтийн хураамж 3300 ХААНБанк 5046309338

Жич: Хугацаа хэтэрсэн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 15.24.1 дэх заалтын дагуу хорин нэгжтэй тэнцэх шийтгэл оногдуулна

АСУУЛТ 5: Би 45 насны сунгалтаа хийлгэх гээд ирлээ. Бүрдүүлэх бичиг баримт юу авчрах вэ.

ХАРИУЛТ5: 25, 45 насны иргэний үнэмлэхний хугацааны сунгалтаа бүртгүүлэхэд дараах бичиг баримтаа авч ирнэ. Үүнд:

-Иргэний үнэмлэх / хугацаа дууссан/

-Өөрийн биеэр ирэх

Үйлчилгээний хураамж: Иргэний үнэмлэхний үнэ 15000

/ХААНБанк 5046310388, ХААНБанк 5046309338/ тэмдэгтийн хураамж 3300 төгрөг тушаах

Жич: Хугацаа хэтэрсэн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 15.24.1 дэх заалтын дагуу хорин нэгжтэй тэнцэх шийтгэл оногдуулна. Харьяалал харгалзахгүй бүртгэл

АСУУЛТ 6: Эгч нь Улаанбаатар хотоос 10-р баг дээр шилжин ирж байгаа бүрдүүлэх бичиг баримт нь юу байхав.

ХАРИУЛТ 6: Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг бүртгүүлэхэд дараах бичиг баримтыг бүрдүүлж ирнэ.

-Иргэний үнэмлэх

-16 нас хүрээгүй хүүхэдтэй иргэн оршин суух бол хүүхдийн төрсний гэрчилгээ

-Оршин суух газрын хаягаа нотлох баримт бичиг / Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ/

-Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ

-Нотариатаар гэрчлүүлсэн түрээсийн, захиалгын гэрээ

-Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эсхүл эзэмшигчийн бичгээр гаргасан / оршин суулгах тухай зөвшөөрөл/

-Эзэмшигч нь хамт ирэх боломжгүй бол өргөдлийг нотариатаар гэрчлүүлнэ

-Аймаг, нийслэлээс -2500 /ХААНБанк 5046293699/

-Сум, баг хооронд -1500 /ХААНБанк 5046293699/

-Тэмдэгтийн хураамж – 1000 / ХААНБанк 5046309338/ тус тус тушааж баримтаа авчрах

АСУУЛТ 7: Манай дүү гадаад паспорт 2 хүүхдэдээ өөртөө авах гэсэн юм ямар баримт бичиг бүрдүүлэх ёстой вэ.

ХАРИУЛТ 7: 16-гаас доош насны хүүхдэд үндэсний гадаад паспорт авахад дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

-Цээж зураг 4% /гадаад паспортын шаардлага хангасан дух, чих ил гарсан 3,5*4,5-ийн хэмжээтэй /

-Төрсний гэрчилгээ, түүний хууль ёсны төлөөлөгчийн иргэний үнэмлэх /эцэг, эх/, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосон шийдвэр, өөрийн биеэр ирэх /5 жилийн хугацаатай/

-Үйлчилгээний хураамж төлсөн хураамж:

-Титан интернейшнл /Хэвлэлтийн үнэ-15000/ Голомт банк -1401001218

-Үйлчилгээний хураамж 12000 /Голомт 1401001081/

-Тэмдэгтийн хураамж -5000 /ХААНБанк- 5046309338/

- Том хүн: Цээж зураг 4% /гадаад паспортын шаардлага хангасан дух, чих ил гарсан 3,5*4,5-ийн хэмжээтэй /

-иргэний үнэмлэх өөрийн биеэр ирэх /10 жилийн хугацаатай/

Үйлчилгээний хураамж төлсөн хураамж:

-Титан интернейшнл /Хэвлэлтийн үнэ-15000/ Голомт банк -1401001218

-Үйлчилгээний хураамж 12000 /Голомт 1401001081/

-Тэмдэгтийн хураамж -5000 /ХААНБанк- 5046309338/

Жич: Харьяалал харгалзахгүй бүртгэл

АСУУЛТ 8: Иргэн : Нас барсны бүртгэл бүртгүүлэхэд юуг үндэслэн бүртгэх вэ? Тэр талаар зөвлөгөө өгнө үү.

ХАРИУЛТ 8: Нас барсны бүртгэлийг бүртгүүлэхэд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

-Эмнэлгийн байгууллагаас олгосон АМ-7 маягт

-Нас барсан иргэний иргэний үнэмлэх

-Бүртгүүлж байгаа иргэний иргэний үнэмлэх

